

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
үйл ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааныг 2019 оны 11-р сарын 12-ны өдөр хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдааны тов зарлах тухай, Шагналын тухай, Өмчийн тухай

Атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 212 дугаар зарлигаар шагнагдсан иргэдийн нэрсийг авч, холбогдох сумдад зар хүргэж, 11-р сарын 26-ны өдрийн баярын хурал дээр гардуулах ажиллагааг зохион байгуулж Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 3, Алтан гадас одонгоор 10, Хөдөлмөрийн хүндэт медалиар 3 иргэн шагнагдсан байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хуулийн хугацаанд хүлээн авч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд хүргүүлсэн бөгөөд хурлын хорооны хурлыг 11-р сарын эхний 10 хоногт багтаан зохион байгуулж гарсан саналыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2019 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 144.915.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 54 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 42.262.3 сая төгрөгөөр санхүүжинэ.

Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 5 төсөл арга хэмжээнд 275.6 сая төгрөг батлагдсанаас оны эхний 11 сарын байдлаар зарцуулалт нь 149.6 сая төгрөг байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7.302.6 сая төсөвт өртөг бүхий 26 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 3.011.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээс оны эхний 11 сарын байдлаар зарцуулалт нь 1.905.1 сая төгрөг байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээнд 132.7 сая төгрөг үүнээс барилга байгууламж 120.0 сая төгрөг, тоног төхөөрөмж 12.7 сая төгрөг тус тус тусгагдсанаас 2019 оны эхний 11 сарын байдлаар зарцуулалт нь 12.7 сая төгрөг байна.

Аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөнийг 11-р сарын 25-ны өдрийн 09.00 цагт Авто тээврийн төвийн сургалтын танхимд зохион байгууллаа.

Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд 51 удирдах албан тушаалтан оролцохоос аймгийн ЗДТГ-ын нэгжийн дарга 5, агентлагийн дарга 19, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын дарга 16, Эрдэнэбулган сумын Засаг дарга, нийт 41 албан тушаалтан оролцож ирц 80.3 хувь байв.

Энэ удаагийн шуурхай зөвлөгөөнөөр аймгийн Засаг даргаас сум, байгууллагын дарга нарт цаг үеийн шинжтэй 7 үүрэг даалгавар өглөө.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу төрийн албан

хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг томилогдсон ажлын хэсэг журам, зөвлөмжийн дагуу боловсруулан 10-р сарын 26-29-ний өдрүүдэд Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаар хянуулан, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 10-р сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-ын Ажлын алба, ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Орон нутгийн өмчийн газар, Эрдэнэбулган сумын ЗДТГ гэсэн 9 байгууллагын 98 албан тушаалд хамаарах 134 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл авч албан тушаалтын тодорхойлолтыг батлах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг Архангай аймагт 2019 оны 11-р сарын 16-наас 21-ний өдрүүдэд зохион байгууллаа. Шалгалтад аймгийн хэмжээнд 207 иргэн цахимаар бүргүүлсэн бөгөөд шалгалтад 185 иргэн оролцож 17 иргэн тэнцсэн байна.

Удирдлагын Академийн Мэргэшил дээшлүүлэх институтээс 11-р сарын 13,14-ний өдрүүдэд аймгийн ЗДТГ-т "Төрийн байгууллагын стратеги төлөвлөлт хийх арга зүй" сэдвээр сертификаттай сургалт зохион байгуулж аймгийн ЗДТГ болон агентлагийн 31 албан хаагчид төрийн байгууллагад стратегийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, төрийн байгууллагын орчны нөхцөл байдлыг тодорхойлох, орчны шинжилгээнд тулгуурлан стратеги тодорхойлох, стратегийн хэрэгжилтийг хангах гэсэн чиглэлээр мэдлэг чадварыг нь дээшлүүлсэн байна.

Засгын газрын 2019 оны 296 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улс орон даяар "Хуримтлалтай-Хувьцаатай иргэн" аяныг зохион байгуулж байгаа бөгөөд энэхүү аяныг Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, аймгийн ЗДТГ Архангай аймагт 11-р сарын 4, 5-ны өдрүүдэд иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, бизнэс эрхлэгчидэд зохион байгуулж иргэдэд "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн 1072 ш хувьцаа, хөрөнгийн зах зээл, үнэт цаасны арилжааны тухай мэдээлэл өгч, хувьцааны данс нээх, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлсэн байна.

Халхын голд зөвлөлт монголын цэргийн байгуулсан Ялалтын 80 жилийн ойд зориулсан Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны өдрүүдийн хүрээнд Архангай аймагт Орос хэл, соёлын бүсийн арга хэмжээг 11-р сарын 8-наас 10-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Арга хэмжээнд ОХУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны зөвлөх, ОШУСТөвийн захирал болон аймгийн удирдлагууд оролцож МУБИС-ийн Архангайн Багшийн сургуульд орос хэлний төвийг нээж, Орос хэлний бүсийн олимпиадыг орос хэлний багш нар, 12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж мөн орос дуу, шүлгийн уралдааныг зохион явуулсан юм.

Орос хэлний багш нарын олимпиадад эхний байруудад шалгарсан 3 багшийг ОХУ-д мэргэжил дээшлүүлэх эрх, 12-р ангийн сурагчдын олимпиадад шалгарсан 2 сурагчийг ОХУ-ын их дээд сургуульд хүссэн мэргэжлээрээ 100 хувийн тэтгэлэгтэйгээр суралцах эрхийн бичгээр тус тус шагнасан бөгөөд бүсийн арга хэмжээнд Архангай, Завхан, Өвөрхангай, Хөвсгөл, Баянхонгор аймгийн багш, сурагчид оролцсон юм.

Флом байгууллагын Архангай аймаг дахь салбар "Гэгээн ирээдүй" төслөөс аймгийн ЗДТГ-тай хамтран "Өрхөөс хөгжил эхэлнэ" сэдэвт чуулга уулзалтыг 11-р сарын 20-ны өдөр зохион байгуулж чуулга уулзалтад зорилтот 10 сум болох Эрдэнэбулган, Цэнхэр, Хотонт, Хашаат, Ихтамир, Чулуут, Тариат, Жаргалант,

Цэцэрлэг, Хайрхан сумдын удирдлагууд болон ТББ, зорилтот иргэдийн төлөөлөл 100 гаруй хүн хамрагдсан байна.

Монгол Улсад байгаль хамгаалах, эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх, хуулийг сахин биелүүлэх, уул уурхайн компаниудыг хариуцлагатай байлгах үүднээс 21 аймагт зохион байгуулж байгаа "Байгаль эх-хариуцлагатай уул уурхай" үндэсний хэлэлцүүлгийг 11-р сарын 21-ний өдөр аймгийн ЗДТГ-т зохион байгууллаа.

Атар газар эзэмшиж, шинжлэх ухааны үндэстэй газар тариалангийн үйлдвэрлэл үүсч хөгжсөний 60 жилийн ойн арга хэмжээг аймгийн ЗДТГ, ХХААГ хамтран Архангай аймагт 11-р сарын 25, 26-ны өдрүүдэд тэмлэглэн өнгөрүүлээ.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлтийн талаар

2019 оны 11-р сард улсын төсөвт 78.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 151.6 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 193.2%, орон нутгийн төсөвт 786.2 сая төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 786.2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 100 хувь биелүүлэхээр байна.

Тайлант хугацаанд 10-р сарын нэмэгдсэн өртгийн албан татварын 217 тайлан цахимаар хүлээн авч тайлангийн ирцийг 100.0 хувьтай хангуулж, шалгуур үзүүлэлт хангаагүй байцаагчид хуваарилагдсан 17 тайланг тайлан хүлээн авах журмын дагуу хүлээн авч баталгаажууллаа.

Нэг цэгийн өрөөгөөр үйлчлүүлсэн 40 гаруй иргэнд нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн талаар зөвлөгөө өгсөн байна.

Өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр

Орон нутгийн өмчит 120 төсөвт байгууллагад 457.6 сая төг-ийн үндсэн хөрөнгө худалдан авах, 14 төсөвт байгууллагад 538 нэрийн 158.6 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 105.6 сая төгрөгний өртөг бүхий нэг ажлын тендер зарласан. УТХО-аар Агаарын бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх хог хаягдал боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Газрын гагнаас" ХХК-ийг шалгаруулан 194.476.081 төгрөгөөр гэрээ байгуулсан. Орон нутгийн сангийн хөрөнгөөр 4 байршилд дахин төлөвлөлт хийх зөвлөх үйлчилгээний ажлын тендерийг зарласан.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Улсын бүртгэлийн чиглэлээр

Улсын бүртгэлийн хэлтэс нь иргэний бүртгэл, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр нийт 2016 иргэнд үйлчилж бүртгэл хийсэн байна.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

2019 оны 11-р сарын 25-ны байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр 1209 бүртгэл хийж гүйцэтгэлээ.

- Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 127
- Гэрлэлтийн бүртгэл -24
- Гэрлэлт цуцалсаны бүртгэл - 2
- Хүүхэд үрчлэлтийн бүртгэл – 5
- Эцэг тогтоосны бүртгэл- 3
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 5

- Нас баралтын бүртгэл - 34
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 100
- Дахин олгосон - 59
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 197
- Үндэсний энгийн гадаад паспорт- 43
- Шилжилт хөдөлгөөн - 104
- Иргэнд - 453 лавлагаа
- Хууль хяналтын байгууллагад - 53 лавлагаа

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:

2019 оны 11-р сарын 25-ны байдлаар нийт эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл 462 мэдүүлгийг хүлээн авч дараах бүртгэлийг хийж гүйцэтгэлээ.

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 22
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 10
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 3
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 82
- Худалдах худалдан авах гэрээ – 49
- Бэлэглэлийн гэрээ – 1
- Барьцааны эрхийн бүртгэл – 274
- Өв залгамжлал – 8
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 5
- Бусад эрхийн бүртгэл – 8

Хууль хяналтын байгууллагад 59 лавлагааг гарган хүргүүлсэн байна. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 3293045 тэмдэгтийн хураамжид 52055 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 9952471 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн чиглэлээр

- Шинэ-6
- Өөрчлөлт-10
- Тамга тэмдэгтийн хяналтын дугаар олгосон-6

Мэргэжлийн хяналтын газраас 11 сарын байдлаар 4575 объектод эрсдэлийн үнэлгээ хийж баталлаа. Үүнд: Их эрсдэлтэй 937, дунд эрсдэлтэй 2188, бага эрсдэлтэй 1450 объект үнэлэгдлээ. 2018 онд үнэлэгдсэн эрсдэлийн ангилалтай харьцуулбал их эрсдэлтэй үнэлэгдсэн объектын тоо 29-өөр, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектын тоо 335-аар, бага эрсдэлтэй үнэлэгдсэн объектын тоо 83-аар нэмэгдсэн байна.

Эрдэнэбулган сумын хяналт шалгалтанд хамрагдсан 24 аж ахуй нэгжид 11 хяналтын чиглэлээр гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж шилэн хяналтын мэдээллийн нэгдсэн санд бүрэн оруулан эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 7 төрлийн 71 ширхэг гарын авлага тараасан.

Шүүхийн шинжилгээний албанаас 11-р сард криминалистикийн шинжилгээ 5, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 54, шүүх эмнэлгийн шинжилгээ 63, тусгай шинжилгээ 34-г тус тус хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 11-р сард гал түймэр, гамшиг осол, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын дуудлага нийт 10 удаа ирснээс, объектын гал түймрийн дуудлага 3, зөрчлийн дуудлага 1, ой хээрийн түймрийн дуудлага 1, гол, нуурын усанд осолдсон 1, эрэн хайх, аврах ажиллагаа 2, мал, амьтны гоц халдварт өвчин 2 удаа тус тус гарсан байна.

Онцгой байдлын газраас Монгол Улсын Шадар Сайдын баталсан гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалт явуулах удирдамжийн дагуу 16 ажлын хэсэг Эрдэнэбулган сумын 6 багийн нийт 1895 айл өрхөд нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн 3678 зөрчил илрүүлж 687 зөрчлийг газар дээр нь арилгуулан гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 9, мэдэгдэл 19-ийг тус тус бичиж холбогдох иргэдэд хүргүүлж биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.

Тус сард гамшгаас урьдчилан сэргийлэх өдөрлөг, нэгдсэн арга хэмжээг 2 удаа зохион байгуулж 1967 иргэнийг хамруулж, 2000 ширхэг санамж боршур тараалаа.

Аймгийн хэмжээгээр 10-р сард 254 хүн гэмт хэрэгт холбогдож 543 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 127, өмчлөх эрхийн эсрэг 289, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 39, байгаль хамгаалах журмын эсрэг 23, бусад 65 хэрэг гарсан байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 219812.7 төгрөгийн мөнгөн дүн бүхий 600 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 50.1, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 29.9 байна.

Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгаас 11-р сард 127 иргэний бүртгэлийг хүлээн авч 168 лавлагаа олгож үйлчилсэн байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр

2019-2020 оны хичээлийн жилд Архангай аймгийн хэмжээнд 33 Ерөнхий боловсролын сургуульд 18192 сурагч суралцаж, 35 цэцэрлэгт 7762 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж, Ерөнхий боловсролын сургуульд 1846 багш, ажилчид, сургуулийн өмнөх боловсролд 760 багш, ажилчид ажиллаж боловсролын үйлчилгээг нийт сурагч, хүүхэд багачуудад хүргэж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Боловсрол, соёл урлагийн газрын ажлын хэсэг Ихтамир, Өндөр-Улаан, Хашаат, Хотонт, Өгийнуур, Төвшрүүлэх, Цэнхэр сумдад ажиллаж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

11-р сарын 28-30-ны өдрүүдэд “Оны бүтээлч багш, бүтээлч байгууллага шалгаруулах үйл ажиллагаа”, “Тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй багш нарын аймгийн зөвлөгөөнийг Эрдэнэбулган суманд зохион байгууллаа.

Соёл урлагийн чиглэлээр

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 25 уншигч шинээр бүртгэж, 1897 ирэгсэдэд 1861 ном, 114 сонин, сэтгүүлээр, хүүхдийн уншлагын танхимаар шинээр 44 уншигч бүртгэж, 1172 ирэгсэдэд 1644 номоор, гэрээр ном

олгох үйлчилгээгээр 15 уншигч шинээр бүртгэж 65 ирэгсэдэд 155 номоор, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр 23 байгууллагад үйлчилж 18 уншигч шинээр бүртгэж, 80 ирэгсэдэд, 233 номоор тус тус үйлчилсэн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 96 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 262.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 101.5 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 15.8 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна. Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98.8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100.0 хувь хамруулсан байна.

Оны эхний 10 сард 1402 эх төрж, 1407 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.7 хувиар буюу 54 хүүхдээр бага байна.

Хүн амын нас баралт 462 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 22 тохиолдлоор буюу 4.8 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 14.7, нас баралт 4.8 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 9.9 промил байна. Төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл 1 гарч, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 11, нялхасын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 21 гарч мянган амьд төрөлтөд 14.9 ногдож байна.

Цэцэрлэг, Хоршооллын Эрүүл мэндийн төвийн автомашины парк шинэчлэлтийг 55.8 сая төгрөг, Цэцэрлэг сумын уурын зуухны халаалтын тогооны засварыг 6 сая төгрөгний өртөгөөр хийсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхдийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор “Сурагчдын эрүүл мэндийг дэмжих, хамгаалахад ангийн багшийн үүрэг, оролцоо” сэдэвт сургалтыг Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн анги даасан багш нарт 10-р сарын 29,30-ны өдрүүдэд зохион байгуулж, 52 багш хамрагдаж, мэдлэгээ дээшлүүллээ.

Засгийн Газрын 2017 оны 11 дүгээр тогтоол “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 327 дугаар тушаал, “Тэмбүүг устгая” үйл ажиллагаа зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2019 оны А/460 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Халдварт болон халдварт бус өвчний цогц илрүүлэг үзлэг, оношилгоо” загвар үйл ажиллагааг Өндөр-Улаан суманд 2019 оны 11-р сарын 1,2-ны өдөр ЭМЯ, ХӨСҮТ-тэй хамтран зохион байгууллаа.

Энэхүү үйл ажиллагаанд Эрүүл мэндийн яам, аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар, сумдын удирдлага, мэргэжилтнүүд, 19 сумын Эрүүл мэндийн төвийн дарга, эмч, эмнэлгийн ажилтнууд зэрэг 65 төлөөлөгч, мөн Нэгдсэн эмнэлгийн 17 эмч, сувилагч оролцон үзлэг, оношилгоонд нийт 538 хүн хамрагдсанаас 345 хүн ямар нэг өвчний шинж тэмдэгтэй илэрч, зөвлөгөө авсан байна.

Биеийн тамир, спортын чиглэлээр

Биеийн тамир спортын тухай хуулийн 10.1.2, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир спортын газрын даргын 2019 оны А/177 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд санамсаргүй түүврийн аргаар бие бялдрын түвшин тогтоох сорилын хоёрдугаар шатны туршиц судалгааг авах сорилын багийн бүрэлдэхүүн хуралдаж 06 -10 нас, 11-14 нас, 15-17нас, 18-29 насны ангиллаар нийт

224 хүнийг сорилд хамруулахаар төлөвлөн 11-р сарын 18- 23-ны өдрүүдэд БТСГазар дээр нийт 190 хүүхэд, насанд хүрэгчид, Цэнхэр сумын ЕБС зааланд 24 сурагч 10 багш ажилчдыг тус тус сорилд хамруулсан байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр

2019 оны 11 сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1166 иргэн бүртгэлтэй байгаагаас 630 эмэгтэй, Байнгын шинэ ажлын байр 868, улирлын ажлын байр 47, түр ажлын байр 362, ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 926, зуучлал 886байна. Тухайн сарын 20-ны байдлаар 210 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 10, бага-42, суурь-204, бүрэн дунд-672, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 26, тусгай мэргэжлийн дунд-23, Дипломын бакалаврын-188, магистр-1 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна.

Шинэ ажлын байрыг эдийн засгийн салбараар нь ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 309, боловсруулах үйлдвэрлэлд 415, Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 55, бусад салбарт 498 ажлын байр шинээр бий болсон байна.

Ажлын байранд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 322, боловсруулах үйлдвэрлэлд 30, барилга 127, үйлчилгээний болон бусад салбаруудад 407 иргэн зуучлагдан орсон байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 10 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч НДХэлтэс рүү хүргүүлсэн.

Их дээд сургууль болон мэргэжлийн боловсролын байгууллагын суралцагчдад ажил мэргэжил чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг 2019 оны 10-р сарын 29-нөөс 11-р сарын 1 хүртэлх хугацаанд “Гурван тамир” МСҮТ, Архангай МСҮТ болон Архангай аймаг дахь Багшийн сургуулийн суралцагчдад зохион байгуулсан. Сургалтад МСҮТ-71, “Гурван тамир” МСҮТ- 32, Багшийн сургууль - 51 суралцагч тус тус хамрагдсан байна.

2019 оны 11-р сарын байдлаар Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй аж ахуй нэгж байгууллагуудад албан тоот хүргүүлэн 6.8 сая төгрөгийн төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлээд байна.

Нийгмийн даатгалын санд 2019 оны 11-р сард нийт 7.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 110 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 15.0 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 44.64 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 51.333 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Нийгмийн даатгалын санд 2019 онд 7.4 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6 тэр бум төгрөгөөр өссөн.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд

- Тэтгэврийн даатгалын санд 66.4 % буюу 10272.7 сая төгрөг
- Тэтгэмжийн даатгалын санд 7.3 % буюу 1150.5 сая төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 5.6 % буюу 881.3 сая төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 1.5 % буюу 243.3 сая төгрөг;

- Эрүүл мэндийн даатгалын санд 19.2% буюу 2368.2 сая төгрөг
2019 оны нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 44.64 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 4.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.
11-р сард тэтгэврийн даатгалын санд 46315.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, улсын төсвөөс 350.0 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд хүлээн авсан. Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 12.7 мянган иргэдийн тэтгэвэрт 43.04 тэрбум төгрөг зарцуулжээ.
Нийт 77.8 хувь буюу 33.5 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 10.2 мянган иргэнд зарцуулсан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр

Хүний эрхийн үндэсний комисс, аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөгжимт драмын театр, Насан туршийн боловсролын төв зэрэг байгууллагууд хамтран сургалт нөлөөллийн арга хэмжээнд 1500, “Хүчирхэг охид” зөвлөгөөнд 250 охидыг хамруулж, 20 төрлийн 2500 ширхэг зурагт хуудас уриалга түгээж охидын мэдлэгийг нэмэгдүүлж, эцэг эх, асран хамгаалагчдын хандлагыг сайжруулсан.

Энэхүү арга хэмжээнд хамтран ажилласан байгууллагуудаас нийтдээ 8.2 сая төгрөг зарцуулж, 5450 охид буюу аймгийн нийт охидын 33.3%-д хүрч ажиллан 1200 охидоос санал асуулга авч үр дүнг нэгтгэн, зөвлөмж чиглэлийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна.

Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяныг зохион байгуулж хүүхдүүдэд мэргэжил сонголтоо зөв хийхэд нөлөөлж, мэргэжлийн талаар мэдээлэл өгч олон нийтэд сурталчилан 972200 төгрөгийн зардлыг шийдвэрлэн 2020 хүүхэд, залуучуудыг хамруулсан байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

2019 оны эхний 10 сарын байдлаар оны эхний хээлтэгч малын 84.6 хувь нь буюу 2002 мянган эх мал төллөж гарсан төлийн 97.2 хувь нь буюу 1945.1 мянган төл бойжсон байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 100 хувь, унаганы 96.7 хувь, тугалын 97.5 хувь хурганы 97.6 хувь, ишигний 96.2 хувь нь бойжсон байна.

Оны эхний мал 99.2 хувиар онд орж оны эхний малын 0.8 хувь буюу 44.8 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 6.2 хувийг адуу, 8.9 хувийг үхэр, 57.7 хувийг хонь, 27.2 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Газар тариалан

2019 оны хавар 9040.0 га-д үр тариа, 264.3 га-д төмс, 126.5 га-д хүнсний ногоо, 1097.9 га-д малын тэжээлийн ургамал, 700 га-д техникийн ургамал тус тус тариалсан нь өмнөх оны энэ үеийнхтэй зэрэгцүүлэхэд үр тариа 30.7 хувиар, төмс 4.9 хувиар, хүнсний ногоо 20.9 хувиар их харин техникийн ургамал 40.5 хувиар, тэжээлийн ургамал 37.2 хувиар бага тариалсан байна.

11-р сарын 1-ний байдлаар аймгийн дүнгээр үр тариа 10581 тн, төмс 2442.4 тн, хүнсний ногоо 1182.2 тн, тэжээлийн ургамал 2730.4 тн, техникийн ургамал 810

тонныг хурааж, байгалийн хадлан 74.5 мянган тн, гар тэжээл 1040.2 тонныг бэлтгээд байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Аймгийн БОАЖГ-аас “Миний нутаг–Миний бахархал” сэдэвт өсвөр үеийнхний эко танин мэдэхүйн аяллыг гурав дахь удаагаа зохион байгуулж Эрдэнэбулган сумын 3-р сургуулийн “Эко” клубын сурагчид оролцжээ.

Ойн хөнөөлт шавж, өвчний судалгааны ажлыг 2016-2019 онд нийт 2628000 га-д гүйцэтгэсэн байна. Судалгааны үр дүнд ойн сан бүхий 14 суманд хөнөөлт шавжийн тархалттай 252749 га талбайг илрүүлж, 55100 га талбайд тэмцлийн ажлыг 91 хувийн техникийн ажлын үр дүнтэйгээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн.

2018 оноос хойш тэмцлийн ажлын үр дүн, уур амьсгалын орчин нөхцөлөөс шалтгаалан ойн хөнөөлт шавж, өвчний тархалттай талбайн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр томоохон голын сав дагуух навчит ойн 13000 га талбайд тэмцлийн ажлыг зохион байгуулна.

2019 онд Архангай аймаг ойгоос 93.2 мянган м3 галын түлээ, 10.6 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 103.9 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 10 сард 63.6 мянган м3 галын түлээ, 8.2 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 71.8 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 210.7 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.

Барилга, дэд бүтцийн чиглэлээр

2019 онд аймгийн хэмжээнд газрын төлбөр 60000,0 мянган төгрөг орохоос 72712,6 мянган төгрөг, Газрын дуудлага худалдаагаас 271873,1 мянган төгрөг орохоос 289564,7 мянган төгрөг орж төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

11 дүгээр сард дараах барилгууд дээр аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг гарч барилгуудыг байнгын ашиглалтанд хүлээн авсан байна. Үүнд:

- 10 дугаар сарын 30-ны өдөр Эрдэнэбулган сумын 1 дүгээр багт “Идэржаваа” ХХК-ийн гүйцэтгэсэн Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын ажилчдын 24 айлын орон сууц

- 11-р сарын 13-ны өдөр “Эсгэл” ХХК-ийн гүйцэтгэсэн Булган сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын засвар өргөтгөлийн ажил